



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БУЙ ЖУРАМ, ЗААВРЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА
БАЙНА**

АУДИТЫН НЭР : ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ
АУДИТЫН КОД: АРА-2026/14-1/ШТА-НА



Цэцэрлэг хот 2026 он

**Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Т.Байгалмаа**

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Н.Алтантуяа

Утас: 7033-2860 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Ахлах аудитор П.Цэцэгдулам

Утас: 7033-3019 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn

Аудитор В.Цогжаргал

Цахим хаяг: tsogjargalb@audit.gov.mn

Аудитор Б.Анхтуяа

Цахим хаяг: ankhtuyalbo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Н.Алтантуяа Ахлах аудитор П.Цэцэгдулам Аудитор В.Цогжаргал Б.Анхтуяа 2026 оны 05 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	Агуулга Товчилсон үгийн тайлбар.....	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Үндсэн мэдээлэл	4-5
	Аудитын тайлан	6-19
	БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨЖ БУЙ ЖУРАМ, ЗААВРЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА БАЙНА	5-11
	1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны журам зааврыг шинэчлэх шаардлагатай байна	
	1.2. Төрийн сангийн үйл ажиллагааны журам, заавар, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай байна	
	БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА	12-19
	2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь хууль, журмын хүрээнд хэрэгжсэн боловч орлогын тасалдал болон төсвийн хязгаарлалтын улмаас зарим байгууллагад батлагдсан төсвөөс дутуу эрх олгогдсон байна	
	2.2. Төрийн сангийн гүйлгээний урьдчилсан хяналтын хүрээнд нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нь зүйтэй байна	
	2.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг тооцоогүй байна	
	Дүгнэлт.....	18
	Зөвлөмж	18
	Уламжлах санал.....	19
	Холбогдох байгууллагын санал	20-21
	Тайлан баталгаажуулсан тушаал.....	22
	Тайлангийн хавсралт.....	23-24



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
МУЕА	<i>Монгол Улсын Ерөнхий аудитор</i>
ШТА	<i>Шууд тайлагнах аудит</i>
СТСХ	<i>Санхүү, төрийн сангийн хэлтэс</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
ОНХНС	<i>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
ТБОНӨХБАҮХАТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль</i>



Хүснэгтийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Албан хаагчдын томилгоо	6
Хүснэгт 2	Хууль, эрх зүйн актууд	7
Хүснэгт 3	Төрийн сангийн 2023-2025 оны гүйлгээний дундаж аймаг, сумдаар	8
Хүснэгт 4	Ажилласан жилийн судалгаа	9
Хүснэгт 5	2023-2025 онд олгосон зарцуулалтын эрхийн судалгаа	12
Хүснэгт 6	ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Төрийн сангийн системээр хийгдсэн нийт гүйлгээний тоо	14
Хүснэгт 8	Түүвэрлэн шалгасан зарлагын гүйлгээ	14-15
Хүснэгт 9	Аймаг, сумдын 2024-2025 оны эрсдэлийн үнэлгээ	18
Хүснэгт 10	Аудитаар өгсөн шийдвэр, түүний хэрэгжилтийн байдал	19

Дүрслэлийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Систем хэрэглэгчийн судалгааны дүн	10
Дүрслэл 2	Төрийн байгууллагын систем хэрэглэгчийн судалгааны дүн	11
Дүрслэл 3	Дансны үлдэгдлийн судалгаа	14



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг ЯАГ-т, аймгийн Засаг дарга, ИТХ, СТСХ-т хүргүүлнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаа, бүтэц чиг үүрэг, хууль тогтоомжийн нийцэл, аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагааны хяналт, цахим системийн ашиглалт, бусад холбогдох баримт материалыг 2023-2025 оныг хамруулан шалгалаа.

Аудитн арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Засгийн газрын тогтоолуудаар Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Засгийн газрын 2001 оны 125 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал”-ын 2.1.3-т “төсвийн санхүүжилтийн гүйлгээг зохицуулах, бүртгэл хийх, тайлан гаргах үүрэг бүхий Төрийн сангийн тогтолцоог хөгжүүлэх” -ээр заажээ.
- ✓ “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” Засгийн газрын 2002 оны 101



дүгээр тогтоолоор Монгол Улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “*төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг*” гэж тодорхойлж, хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг, Төв төрийн сангийн чиг үүргүүдийг хуулиар зохицуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “*Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ*” гэж заасны дагуу 2002 онд Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжиж системийн хөгжүүлэлт сайжруулалтыг тухай бүр хийж ирсэн байна.

Аймгийн хэмжээнд Санхүү төрийн сангийн хэлтэст -7, 19 сумын төрийн санд 38-н төрийн сангийн чиг үүрэг бүхий албаны дарга, төлбөр тооцоо хариуцсан мэрэжилтэн ажиллахаар батлагдснаас, гүйцэтгэлээр 43 албан хаагч ажилаж, 2 төлбөрийн тооцооны мэргэжилтний орон тоо сул байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системд 209 төсвийн байгууллагын 1089 дансанд 43 хэрэглэгч хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨЖ БУЙ ЖУРАМ, ЗААВРЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА БАЙНА

1.1 Төрийн сангийн үйл ажиллагааны журам зааврыг шинэчлэх шаардлагатай байна

1.1.1. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд хоорондоо нийцэж байна уу гэсэн асуудал орон нутагт хамааралгүй болно.

1.1.2. Аймгийн хэмжээнд 2023-2025 онд Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3¹, 3.1.10²-т заасны дагуу нийт 34 нягтлан бодогч томилогдсноос санхүү албаны дарга 7, төсөвт байгууллагын нягтлан бодогч 27 байна. Тухайн албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 6-р бүлэгт тусгагдсан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмын дагуу томилогдсон байна.

¹ 3.1.3. Сум, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн;

² 3.1.10. Аймаг, нийслэл, сумын төсөвт харъяалагдах байгууллагын ахлах нягтлан бодогчийг байгууллагын дарга аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөн;



Хүснэгт №1 Албан хаагчдын томилгоо

Зөвшилцсөн байдал	2023 он	2024 он	2025 он
Аймгийн Засаг даргатай	3	1	3
Төрийн сангийн хэлтсийн даргатай	5	15	7
Дүн	8	16	10

Харин аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн тухайд аймгийн ЗДТГ-ын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй түр орлон гүйцэтгэгчийг томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2³, 31 дүгээр зүйлийн 31.1.1⁴ дэхь заалтыг

зөрчсөнд аудитаас 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 ны 329 дүгээр тушаалаар “Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг аймаг, нийслэл, дүүрэгт хэрэгжүүлэх журам”-ын 1.3-т “Дараах албан тушаалтныг төлөөлөгчөөр томилно” 1.3.1-д “Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга”, 1.3.2-т “Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн” гэж заасан байна. Үүний дагуу аймгийн Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, нягтлан бодох бүртгэлийн ахлах мэргэжилтэн нар санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчийн ажлыг давхар гүйцэтгэж журмын 3.2.3-т заасны дагуу нэмэгдэл хөлс авч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.6.10-2.6.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг мөн журмын 2.5.6-д заасантай адилаар санхүүжүүлнэ” гэж заасан боловч тус журамд **2.6.10-2.6.14** дэх заалт тусгагдаагүй байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.2-т “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт нь бусад хяналтын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаатай давхардахгүй бөгөөд **эрсдэлд суурилсан** зарчмыг баримтлан учирч болох эрсдэлийг бууруулахад чиглэгдэнэ” гэж заажээ.

Харин Сангийн сайдын 2024 оны 254 дүгээрр тушаалаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 5.1.1-д зааснаар дотоод хяналтыг тухайн шатны төрийн сангийн өөрсдийнх нь тодорхойлсон эрсдэлд суурилж төлөвлөж, гүйцэтгэхээр байгаа нь дээрх журмын заалттай нийцэхгүй байна.

³ 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ”,
⁴ 31.1.1-д “энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй”,



1.2. Төрийн сангийн үйл ажиллагааны журам, заавар, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай байна

1.2.1. Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцийг тогтоож Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, дотоод хяналт нь дараах эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

Хүснэгт №2 Хууль, эрх зүйн актууд

Үзүүлэлт	Эрх зүйн акт	Баталсан огноо	Хууль, эрх зүйн нэр
Бүтэц, зохион байгуулалт	Засгийн газрын 101, 326 дугаар тогтоол	2002 он, 2014 он	Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив
Чиг үүрэг	Төсвийн тухай хууль	2011 он	37 дугаар зүйл. Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг: 37.1.1-37.1.8 дахь заалт
Үйл ажиллагаа	Сангийн сайдын 431 дүгээр тушаал	2016 он	Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, заавар
	Засгийн газрын 444 дүгээр тогтоол	2023 он	Төрийн сангийн үйл ажиллагааны журам
Дотоод хяналт	Сангийн сайдын 05 дугаар тушаал	2014 он	Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам
	Сангийн сайдын 254 дүгээр тушаал	2024 он	Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар

Эх сурвалж: Хууль, эрх зүйн нэгдсэн сайт

Суманд санхүү албаны дарга-1, төрийн сангийн мэргэжилтэн-1, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргын тамгын газар, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан хариуцсан 1 нягтлан бодогч ажиллаж байгаа бол соёл, спортын байгууллагыг эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч хавсран гүйцэтгэж байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 326-р тогтоолоор баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 2.1⁵, 2.2⁶ дахь заалттай уялдахгүй байна.

Мөн уг тогтоолын 1.4.2-т “татварын байцаагч нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалагдах бөгөөд санхүүгийн албаны даргын шуурхай удирдлагад ажиллана” гэж зохицуулсан боловч удирдлагын тогтолцоо нь өөр байгууллагын бүтцэд хамаарч байгаа тул бодит байдал дээр санхүүгийн албаны даргын шууд удирдлагад ажиллах нөхцөл бий болоогүй байна.

⁵ 2.1 Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба нь дараахь төсвийн байгууллагууд болон орон нутгийн хөгжлийн сан, тусгай сангууд, Засаг даргын нөөц хөрөнгийг хариуцан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх 2 нягтлан бодогчтой байна”. Үүнд: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; Сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга, Соёл, спортын байгууллага, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, тусгай сангууд

⁶ 2.2 Хэрэв суманд дээр дурдсанаас олон тооны төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол ажлын ачааллыг харгалзан 2-3 данс хариуцсан 1 нягтлан бодогчтой байхаар



Засгийн газрын 2014 оны 326 дугаар “Санхүүгийн алба байгуулах тухай” тогтоолд сумдын ЗДТГ-ын бүтцэд санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг хамааруулж баталсан нь Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалт мөн хуулийн 19.6.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтод Орон нутгийн хөгжлийн сан болон ХХС-ийн ажил гүйлгээнд хоёрдугаар гарын үсэг зурж, санхүүгийн тайлан баланс гаргах гэж тусгасан нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 1.1.5, 2.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн зохицуулалттай нийцэхгүй байна.

Мөн төрийн сангийн ажилтнуудыг аймаг, сумын ЗДТГ-ын даргын тушаалаар томилж, чөлөөлөн, үр дүнгийн гэрээ байгуулж байгаа нь төсвийн хэрэгжилтийг хангах, төлбөр тооцооны гүйлгээг хийх, тайлагнах, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Төрийн сангийн гүйлгээний тоонд үндэслэн төрийн сангийн албан хаагчдын ажлын ачаалалд дүн шинжилгээ хийхэд аймаг, сумдын төрийн санд 2023-2025 онд нийт 282215 гүйлгээ хийгдснээс 29.0 хувь буюу 81475 гүйлгээг аймгийн төрийн сан, 14.0 хувь буюу 39676 гүйлгээг аймгийн төвийн сум болох Эрдэнэбулган сумын төрийн сан, 57.0 хувь буюу 161064 гүйлгээг бусад сумдын төрийн санд хянаж байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №3 Төрийн сангийн 2023-2025 оны гүйлгээний дундаж аймаг, сумдаар

№	Төрийн сан	Нийт гүйлгээний тоо	Үүнээс:		
			Жилийн дундаж	Сарын дундаж	Өдрийн дундаж
1	Сумд /18 сум/	161064	2983	249	12
2	ЭБ сум	39676	13255	1102	52
3	Аймаг	81475	27158	2263	108
	Дүн	282215	43396	3614	172

Дээрх судалгаанаас харахад аймгийн төрийн сангийн тухайд 2 албан хаагч жилд дундажаар 27158, сард 2263, өдөрт 108 гүйлгээг хянасан байна. Мөн нууцын байгууллагын фрийбаланс системээр хийгдсэн 1254 зарлагын гүйлгээг холбогдох эдийн засгийн ангилал, анхан шатны баримтыг үндэслэн хянаж, баталгаажуулсан байна.

Харин сумдын төрийн сангийн албан хаагчид жилд дундажаар 2983, сард 249, өдөрт 12 гүйлгээг хянаж баталгаажуулдаг бол адил орон тоотой аймгийн төвийн Эрдэнэбулган сумын төрийн сангийн албан хаагчдын хувьд жилд дундажаар 13255, сард 1102, өдөрт 52 гүйлгээг хянаж, баталгаажуулж байгаа нь ажлын ачаалал харилцан адилгүй байна.

Дээрх байдлаас үзэхэд төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц, зохион байгуулалтын оновчтой байдал, орон тооны нормыг бодит ачаалалд нийцүүлэх,



хүний нөөцийн зохистой хуваарилалт зэрэг асуудлуудад сайжруулалт хийх шаардлагатай байна.

1.2.2. Аймгийн хэмжээнд нийт 43 албан хаагч төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлдэгээс аймгийн төрийн санд 7, сумдын төрийн санд 36 албан хаагч ажиллаж байна. Харин 2 суманд төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний орон тоо дутуу байна. Албан хаагчдыг ажилласан жилээр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №4 Ажилласан жилийн судалгаа

<u>Албан хаагчдын тоо</u>	43	Нийт албан хаагчдын 58.2 хувь нь 5-аас дээш жил, 11.6 хувь нь 3-5 жил, 18.6 хувь нь 1-3 жил, 11.6 хувь нь 1-ээс доош ажиллаж байгаа албан хаагч байгаа нь аймгийн хэмжээний төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй албан хаагчид нь харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байна .
<u>Ажилласан жилээр /хувиар/</u>		
1-с доош жил	11.6	
1-3 жил	18.6	
3-5 жил	11.6	
5-с дээш жил	58.2	

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-аар 25 ажил үүргийн хуваарийг баталсан бол Төрийн албаны зөвлөлийн жишиг албан тушаалын тодорхойлолтод санхүүгийн албаны дарга 46, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 23 чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусгажээ. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн нийцлийг авч үзвэл дараах байдалтай байна.

- ✓ Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 2 дугаар зорилтод Санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчийн ажлын чиг үүрэг тусгагдсан байхад Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 329 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг аймаг, нийслэл, дүүрэгт хэрэгжүүлэх журам”-ын 2.4-т заасны дагуу нэмэгдэл хөлс авч байна. Мөн албан тушаалын тусгай шаардлагад мэргэшсэн нягтлан бодогч байх гэсэн заалтыг тусгаагүйгээс “*Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана*” гэсэн чиг үүрэг хэрэгжихгүй байна.
- ✓ Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад улсын ахлах байцаагчийн эрх олгосон хэдий ч нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах чиг үүрэг нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй байна.
- ✓ Сумын санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын 3 дугаар зорилтын 4-т “Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах, холбогдох байгууллагад дурдсан хугацаанд хүргүүлэх” гэж тусгасан нь нийгмийн хөгжлийн бодлогын мэргэжилтний чиг үүргийг давхар гүйцэтгэж байна. Мөн ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааны тендерт оролцон төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байгаа нь төлбөр тооцоог хянаж, батлах чиг үүрэгтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.
- ✓ Аймгийн хэмжээнд 2 суманд төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан

мэргэжилтний орон тоо сул, албан тушаалын чиг үүргийг сумын Санхүү албаны дарга гүйцэтгэж байгаа нь хяналт сулрах эрсдлийг нэмэгдүүлж байна.

Харин аймгийн CTCX, сумын санхүүгийн алба, төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан албан хаагчдаас авсан санал асуулгын дүнгээр “Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг үү” гэсэн асуулгад 88.4 хувь нь “**Бүрэн нийцдэг**” гэж хариулсан бол “Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг үү” гэсэн асуулгад 86 хувь нь “**Үгүй**” гэж хариулсан нь бодит байдалтай уялдаагүй гэж үзэхээр байна.

1.2.3. Төрийн сангийн албан тушаалтнууд нь тус тусдаа өөрсдийн нэвтрэх эрхээрээ Төрийн сангийн удирдлагын цахим систем [/https://finance.gov.mn/](https://finance.gov.mn/)-ээр нэвтэрч гүйлгээг хянаж, батладаг байна.

Аудитын явцад төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар төрийн сангийн хэрэглэгч буюу хянах, батлах эрх бүхий нийт 38 албан хаагч, төсвийн байгууллагын 164 хэрэглэгчээс 7 асуулгын хүрээнд судалгаа авч нэгтгэлээ.

✓ **Төрийн сангийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчдаас авсан судалгааны тухайд:**

Дүрслэл №1 Систем хэрэглэгчийн судалгааны дүн




-Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ гэсэн асуулгад хамрагдсан албан хаагчдын 53 хувь нь “**Бүрэн хангаж байна**”,

-Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ гэсэн асуулгад 52.6 хувь нь “**Интернэтийн саатал**”,

-Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан уу, Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан орон зай үл хамааран гүйцэтгэх боломжтой юу гэсэн 2 асуулгад 100 хувь “**Туйм**” гэсэн хариултыг өгсөн байна.

✓ **Төрийн сангийн цахим системийг ашигладаг төсөвт байгууллагын хэрэглэгчдээс авсан судалгааны тухайд:**

Дүрслэл №2 ТБ-ын систем хэрэглэгчийн судалгааны дүн



-Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ гэсэн асуулгад хамрагдсан албан хаагчдын 53.7 хувь нь **"Хэвийн"**,

-Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ гэсэн асуулгад 36 хувь нь **"Интернэтийн саатал"**,

- Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан уу гэсэн асуулгад 64 хувь нь **"Хэвийн"**,

- Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу гэсэн асуулгад 95.7 хувь нь **"Тийм"**,

-Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу гэсэн асуулгад 77.4 хувь нь **"Тийм"**, 22.6 хувь нь **"Үгүй"** гэсэн байна.

-Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг үү гэсэн асуулгад 64.6 хувь нь **"Тийм"**, 28.7 хувь нь **"Удааширалтай"**, 6.7 хувь нь **"Үгүй"** гэж хариулсан байна.

Мөн төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар саналаа бичнэ үү гэсэн асуулгад төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлдэг 38 албан хаагчдын 97.4 хувь нь "Санал байхгүй" гэсэн бол төсвийн байгууллагын 164 хэрэглэгчээс дараах саналуудыг өгсөн байна. Үүнд:

- ✓ Программын шинэчлэлт, хөгжүүлэлтийг ажлын бус цагаар хийж, эргэх холбоотой байх;
- ✓ Сар улирал жилийн эцсээр программ ачааллаад маш их гацдаг;
- ✓ Бусад системтэй холбогдох хөгжүүлэлтийг хийж сайжруулах тухайбал шилэн дансны систем рүү 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээг шууд татах;
- ✓ Гар утсан дээр ажиллах байдлыг сайжруулж, төсвийн байгууллагаас гүйлгээ илгээсэн тохиолдолд төрийн сангийн гүйлгээ хянадаг, баталдаг албан хаагчдад мэдэгдэл ирдэг байх;

Систем ашиглалтын талаар 2 төрлийн хэрэглэгчээс авсан судалгаанаас дүгнэхэд Төрийн сангийн цахим систем нь аюулгүй байдал, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан, орон зай үл хамааран төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой, хүний хүчин зүйлээс хамаарах эрсдлийг



бууруулсан зэрэг **давуу талууд** байгаа ч хэрэглэгчдээс хөгжүүлэлт, шинэчлэл хийхийг саналд тусгасан байна.

Харин тухайн систем нь цахим орчинд ашиглагддаг тул сум, орон нутгийн интернэтийн хурдаас шалтгаалан удааширах, гацах зэрэг саатал гардаг нь хэрэглэгчийн хувьд хүндрэл үүсгэдэг байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь хууль, журмын хүрээнд хэрэгжсэн боловч орлогын тасалдал болон төсвийн хязгаарлалтын улмаас зарим байгууллагад батлагдсан төсвөөс дутуу эрх олгогдсон байна

Төв төрийн сан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8⁷ дахь заалт болон Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу батлагдсан төсөв, төсвийн хуваарьт үндэслэн санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллага, төрийн өмчийн барилгын тогтмол зардал, төсөл, сангийн төсвийн зарцуулалт болон санхүүжилтийн эрхийг олгож, аймаг, сумын төрийн сан байгууллагын бүртгэлийн дансанд хуваарилан ажилласан байна.

Гэвч 2023-2025 оны гүйцэтгэлээс харахад зарим тохиолдолд батлагдсан төсөвтэй харьцуулахад санхүүжилтийн болон зарцуулалтын эрх **дутуу олгогдсон зөрүү** байна.

Хүснэгт №5 2023-2025 онд олгосон зарцуулалтын эрхийн судалгаа

/сая төгрөгөөр/

Он	Батлагдсан жилийн төсөв	Олгосон зарцуулалтын эрх	Олгосон санхүүжилтийн эрх	Зөрүү	
А	1	2	3	4=1-2	5=2-3
2023	39,009.4	39,009.4	36,685.7	0.0	2,323.7
2024	53,391.0	53,391.0	51,716.2	0.0	1,674.8
2025	57,860.3	56,293.2	56,175.9	1,567.1	117.3

- ✓ 2023 онд батлагдсан хуваарийн дагуу зарцуулах эрхийг бүрэн олгосон боловч зарцуулагдаагүй 2,154.7 сая төгрөгийн санхүүжилтийг эрх олгоогүй, мөн ОНХНС-аас аймгийн ОНХС-д 169.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.
- ✓ 2024 онд зарцуулах эрхийг бүрэн олгосон боловч хуваарийн дагуу зарцуулагдаагүй 1,170.4 сая төгрөгийн санхүүжилтийн эрх дутуу олгогдсон байна. Харин ОНХНС-аас санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой 2 суманд

⁷ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.



504.5 сая төгрөгийн ОНХС-ийн орлогын шилжүүлэг дутуу олгогдсон.

- ✓ 2025 онд батлагдсан төсвөөс 1,567.1 сая төгрөгийн зарцуулалтын эрх дутуу олгогдсон нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хүрээнд зарим зардлыг хязгаарласантай холбоотой байна. Харин ОНХНС-аас төвлөрүүлэх орлого тасалдсантай холбоотой 117.3 сая төгрөгийн санхүүжилт аймагт дутуу ирсэнтэй холбоотой сумдад орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

Сүүлийн 3 жилээс харахад ОНХС-ийн орлогын шилжүүлэг хуваарийн дагуу бүрэн олгогдоогүй байна. Үүнд:

Хүснэгт №6 ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Он	Үзүүлэлт	Олгосон санхүүжилт				Нийт
		I улирал	II улирал	III улирал	IV улирал	
2023	Төлөвлөгөө	1,390.10	2,931.50	3,209.40	3,209.40	10,740.40
	Гүйцэтгэл	1,373.20	2,748.40	3,255.40	3,194.30	10,571.30
	Зөрүү	16.90	183.10	-46.00	15.10	169.10
2024	Төлөвлөгөө	2,181.90	3,302.40	3,302.40	3,904.10	12,690.80
	Гүйцэтгэл	2,181.90	3,250.20	3,364.60	3,389.70	12,186.40
	Зөрүү	0.00	52.20	-62.20	514.40	504.40
2025	Төлөвлөгөө	2,613.90	3,953.20	2,007.50	1,123.80	9,698.40
	Гүйцэтгэл	1,015.30	1,819.80	2,835.90	3,910.10	9,581.10
	Зөрүү	1,598.60	2,133.40	-828.40	-2,786.30	117.30

ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн зарцуулах эрхийг сангийн яамнаас батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу олгоогүйгээс оны эцэст олгосон нь 9 сумын ОНХС-нд 555.8 сая төгрөгийн өр үүсэхэд нөлөөлсөн байна.

2.2. Төрийн сангийн гүйлгээний урьдчилсан хяналтын хүрээнд нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нь зүйтэй байна

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.24⁸-т заасны дагуу төрийн сангийн дансны үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан ажиллажээ.


Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансны үлдэгдлээс үзэхэд жил бүр 9,003.2-13,839.2 сая төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна. Үлдэгдлийг дэлгэрнгүй харуулбал:

Дүрслэл №3 Дансны үлдэгдлийн судалгаа

⁸ Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна.



/сая төгрөгөөр/



Графикаас харахад дансны үлдэгдлийн 34-70 хувийг барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна. Энэ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барьцаа, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн баталгаат хугацааны баталгаа, мөн дутуу олгогдсон санхүүжилтын үлдэгдэлтэй холбоотой байна.

Харин 2025 оны байдлаар нийт үлдэгдлийн 58.1 хувь буюу 6,430.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл эзэлж байгаа нь төсвийн байгууллагын зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлдэг зохицуулалт болон төсвийн хэмнэлтийн горимтой холбоотой байна.

2.2.2. Төрийн сангийн цахим системд бүртгэлтэй 1089 дансаар дамжуулан 2023-2025 онд нийт 964,370.8 сая төгрөгийн 282215 зарлагын гүйлгээ хийгдэж баталгаажсан. Үүнийг гүйлгээний төлөвөөр дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №7 Төрийн сангийн системээр хийгдсэн нийт гүйлгээний тоо

/сая төгрөгөөр/

Он	Банк хооронд илгээсэн		Амжилтгүй		Буцаасан		Нийт	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
2023 он	84891	223,554.3	2789	6,087.9	4136	8,093.9	91816	237,736.1
2024 он	94731	329,591.2	1878	3,991.0	3103	13,914.0	99712	347,496.2
2025 он	86328	360,634.7	1631	7,035.0	2728	11,468.8	90687	379,138.5
Дүн	265950	913,780.2	6298	17,113.9	9967	33,476.7	282215	964,370.8

Аудитаар нийт 24,864.7 сая төгрөгийн 7488 зарлагын гүйлгээг түүвэрлэн үндэслэх анхан шатны баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн эсэхийг тулган шалгалаа. Үүнийг аймаг, сумдаар дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт №8 Түүвэрлэн шалгасан зарлагын гүйлгээ

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Нийт гүйлгээний		Түүвэрлэн шалгасан гүйлгээний		Үүнээс:			
						Эдийн засгийн ангилал зөрүүтэй гүйлгээний		Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээний	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн



1	Өндөр-Улаан	10421	24,507.1	248	438.40	59	93.7	19	34.7
2	Чулуут	10244	21,520.0	324	603.80	33	24.3	102	201.0
3	Цахир	7746	17,122.9	516	662.30	26	13.5	80	72.3
4	Хангай	8080	16,813.2	427	392.70	63	29.9	14	29.4
5	Тариат	10159	28,664.8	377	952.60	14	7.5	84	510.7
6	Эрдэнэмандал	8821	27,830.2	197	319.7	98	103.8	51	121.2
7	Жаргалант	8914	24,232.2	189	391.7	29	26.3	116	124.8
8	Цэцэрлэг	7630	19,348.4	175	236.4	22	11.6	33	53.9
9	Хайрхан	7753	21,395.1	195	914.7	36	10.5	24	99.7
10	Хашаат	9004	17,189.5	74	107.5	8	1.1	23	51.1
11	Өгийнуур	7940	17,044.9	106	349.5	13	7.3	24	104.5
12	Хотонт	10279	23,561.6	104	285.6	18	6.0	30	128.4
13	Ихтамир	10360	24,884.1	55	313.1	7	12.1	45	153.0
14	Батцэнгэл	8470	17,213.8	177	464.2	9	4.9	11	55.9
15	Цэнхэр	10383	26,200.6	85	286.5	7	4.7	41	139.6
16	Булган	8082	16,773.4	93	329.1	25	31.9	23	116.4
17	Өлзийт	8219	20,075.6	122	215.5	55	43.9	16	64.1
18	Төвшрүүлэх	8565	16,703.5	138	259.6	17	1.2	18	82.0
19	Эрдэнэбулган	39676	126,995.8	1437	3322.2	24	29.9	47	163.6
20	Аймаг	81469	456,225.5	2449	14019.6	37	68.1	12	22.7
ДҮН		282215	964,370.8	7488	24,864.7	600	532.0	813	2,328.9

Түүвэрлэн шалгахад 2,860.9 сая төгрөгийн нийт 1413 гүйлгээтэй холбоотой зөрчил илэрснээс хөтөлбөр зориулалт, эдийн засгийн ангилал зөрүүтэй 532.0 сая төгрөгийн 600 гүйлгээ, хяналтын хэсэгт анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,328.9 сая төгрөгийн 813 гүйлгээ байна.

Дээрх зөрчилд аудитаас "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.7⁹, 3.4.10¹⁰ дахь заалт, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" тушаалыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

2.2.3. Аймаг, сумдын төрийн сангаас 2023-2025 онд нийт гүйлгээний 3.5 хувь буюу 9967 гүйлгээг буцаасан байна. Төрийн сангийн ажилтан хянаж буцаасан 7694 гүйлгээний 48.9 хувь нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, 40.5 хувь нь хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу, 10.6 хувь нь хууль, журам зөрчсөн бусад шалтгаантай байна.

Харин 72 цагийн дотор баталгаажуулаагүйгээс систем автоматаар буцаасан 2273 гүйлгээ байна. Энэ нь нийт буцсан гүйлгээний 22.8 хувийг эзэлж байна. (Дэлгээнгүйг хавсралт №1 -ээс үзнэ үү.)

⁹ Төсвийн байгууллага бүртгэлийн данснаас зарлагын гүйлгээ хийхдээ энэ журмын 2 дугаар хавсралтад заасан "маягт ТТ-2А"-ийн дагуу төлбөрийн хүсэлтийг 2 хувь үйлдэн гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулан, хяналтын хэсэгт тусгасан үндэслэх баримтын эх хувийн хамт харьяа төрийн санд ирүүлэх, эсхүл цахимаар баталгаажуулан илгээнэ. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна.

